

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВД БАЙРЛАЖ БУЙ ИРГЭДИЙН 2024 ОНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

2024 оны 12 дугаар сарын 09

Улаанбаатар хот

ЗОРИЛГО: Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйлчилгээний хүртээмж, чанарыг үнэлэх


ХАМАРСАН ХҮРЭЭ: Нийгмийн хамгааллын тусгай төвийн түр хоноглох байрны үйлчилгээ авч буй 33 - 64 насны 25 эмэгтэй, 72 эрэгтэй 97 иргэн оролцсон бөгөөд 97 асуулга бөглөгдсөн байна.

АСУУЛГЫН БҮТЭЦ: Нийт 10 асуулттай, хаалттай асуулт 9, нээлттэй асуулт 1, түүнчлэн асуулгын бүтэц хагас хаалттай хэлбэртэй явагдсан.

Үр дүнд чиглэсэн асуулт 1, харилцаа хандлагад чиглэсэн 1, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн 8 асуултаас тус тус бүрджээ. / Хавсралт 1-ээс харна уу/


1.Нийгмийн хамгааллын тусгай төвөөр хэр удаан үйлчлүүлж байна вэ? Гэсэн асуултын хариултыг график 1-т харууллаа.

График 1



Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, байрны багш, жижүүр, тогоочийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийн талаар 3, 4,5,6,7,8 -дугаар асуултад өгсөн хариултыг график 2-оос харна уу.

График 2




Нийгмийн ажилтан, байрны багш, сэтгэл зүйч, эмч, жижүүр, тогоочийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг маш сайн гэж 42%-58% хүртэл, мөн 42%- 55% хүртэл хангалттай гэж үнэлсэн байна. Харин 4% - 8% нь хангалтгүй гэсэн байна.

3. Албан хаагчдын харилцаа хандлага, жижүүр хоолны амт чанар, төвийн ая тухтай байдал үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 2,9-дугаар асуултад өгсөн хариултын үр дүнг график 3-аас харна уу.

Албан хаагчдын харилцаа хандлага болон төвийн ая тухтай байдал үйлчилгээг 48%- 62% маш сайн, 52%-57% хангалттай гэж үнэлсэн.

График3

4. Тус төвийн үйл ажиллагааг та цаашдаа ямар байгаасай гэж хүсэж байна вэ? Гэсэн



нээлттэй асуултын хариултыг хүснэгтэнд харуулав.

Жич:Судалгаанд судлаачийн зүгээс субъектив нөлөөлөл оруулахгүйн тулд үйлчлүүлэгч иргэдээс ирсэн санал хүсэлт, шүүмж, талархлын үг өгүүлбэрийг засваргүйгээр оруулсан болно.

Хүснэгт 1

	Санал, хүсэлт	Шүүмж	Талархал
1	Энэ үйл ажиллагаа хэвийн байвал зүгээр байна	Хоол хүртээмжгүй байна. Ажлаас ирэхэд хоол байхгүй. Харуул хамгаалалтын ажилтан дээр хоол тавьж баймаар байна.	Энэ байдлаараа эрч хүчээ алдахгүй байгаарай
2	Хамтран ажиллагч байгууллага болон бусад байгууллагаас яриа таниулга тогтмол явуул байвал сайн. Бүлэг болгон тогтмол явуулж байвал тогтворжих магадлал өндөр. Гэгээн өглөө – Харилцаа, хандлага хөтөлбөртэй явуулах. Даалгавар өгөх, үйлчлүүлэгч иргэдийг оролцуулбал сайн байна:	Хүн бүрт тэгш байвал зүгээр зарим орж гарах нь асуудалгүй юм. Маш олон гарч орж байна. Гарч хэд хоног архи уугаад буцаад л ордог зарим нь үг дуугүй хөөгдөөд гардаг.	Одоо байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байгаа
3	Тус төвийн үйл ажиллагаа цаашид улам сайн сайхан байгаасай гэж хүсэж байна	Хоол нь тостой, ногоо ихтэй, мах багатай	Тус төвийн ажиллагаа цаашдаа энээс илүү сайхан өргөжиж ядарсан орон гэргүй бид нарт сайн үйлчилж байна. Энэ хамт олонд баярлаж явдагаа дахин дахин хэлмээр байна. Баярлалаа
4	2-р хоол өгч болдог болов уу?	Эрүүл мэндийн талаар сайн анхаарах , хүн нэг бүрт хандаж ажиллах	Нийгмийн ажилтантай ганцаарчлан уулзахад мэргэжлийн ур чадвараа гаргаж сэтгэл тайвширдаг.
5	Шинэ байранд орохдоо тэндээ газар тариалан, гар урлал гэх мэт 2 талдаа ашигтай ажлын байртай болох	Хүмүүстэй зөв харьцаж санал хүсэлтийг сайн авч байх	Тус төвдөө маш их баярлаж явдаг. Албан хаагчид маш сайн хүмүүс.
6	Улам сайн байгаасай	Нэр бүхий жижүүр, тогооч харилцаа хандлагдаа анхаарах	3 тогооч маш сайн хөөрхөн хүмүүс
7	Нийт массыг хамарсан хүртээмжтэй сургалт, нийгэмших бололцоогоор хангах, төрийн бус байгууллагын үйлчилгээний байгууллагуутай хамтран ажиллах		Гэрэлмаа, Хорлоо эмч нар сайн хүмүүс чадалтай мэргэжилдээ үнэнч хүн

8	Цаашдаа хүн бүрийн эрх тэгш ялгарварлахгүй нийтэч хандаасай гэж хэлэх байна		Нийт албан хаагчиддаа ажлын амжилт хүсье Сэтгэл зүйчтэй ганцаарчлан уулзаад ярилцахад сэтгэл онгойж мэргэжлийн ур чадвараа гаргаж чаддаг
9	Хүмүүсийн харилцаа хандлагыг сайжруулахад шаардлагатай сургалтыг нэмэгдүүлэх		Энэ төв энэ янзаараа сайхан байгаасаа гэж хүсэж байна. Бүх албан хаагч ажилчдад баярлаж явдаг шүү
10	Ажлын байртай баймаар байна		Сэтгэл зүйчтэй ганцаарчлан уулзаад ярилцахад сэтгэл онгойж мэргэжлийн ур чадвараа гаргаж чаддаг
			Буянсүрэн багш хөөрхөн ааштай цэмцгэр багш
			Тус төвийн үйлс дээшээ дэвжиг
11	Төвийн үйл ажиллагаа хэвийн сайн байдаг энэ хэвээрээ байхад болно		Улам бүр сайжирна гэж бодож дэмжиж явдагаа. Маш их баярлалаа
12	Олон нийтийн арга хэмжээ нэмвэл сайн байна		Миний хувьд сэтгэл хангалуун байгаа халуун ус, угаалга, үзэж, харах, унших ном бүх юм байна даа
13	Тус төвийн үйл ажиллагааг урд урьдыгхаас илүү сайн ажил төрөлд зуучилж ажилд олон хүн хамруулж байгаасай гэж хүсэж байна.		Энэ үйлчилгээнл маш сэтгэл хангалуун байдаг баярлалаа.
14	Энэ байдгаараа маш сайн байгаасай гэж хүсэж байна		Тус төвийн албан хаагч, ажилтнуудад багш нарт ажлын амжилт хүсье
15	Эвтэй найртай байя даа		Тус төвийн үйл ажиллагаанд сэтгэл ханамж хүртээмж сайтай байгаад баярлалаа
16	Хүмүүсийн харилцаа хандлага, үйлчилгээ үйл ажиллагаа энэ хэвээрээ үргэлжлэхэд хэвийн байна. Дасгал хөдөлгөөний тал дээр жоохон анхаарлаа хандуулах.		Юуны өмнө танайхаар үйлчлүүлсэнд талархаж байна.
17	1.Эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах		Бүх зүйл сайхан хангалуун байгаа.

	2. 2 эмчтэй байх 3. Сэтгэл зүйн эмчтэй байх 4. Сувилагчийн тоог нэмэх		
18	Уг үйлчилгээг үзүүлж байгаа НХТТөв нь олон салбар нэгжтэй байгаасай гэж хүсэж байна.		Ажлын хамт олонд ажлын амжилт, эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэе.
19	Олон хүмүүсийг төвдөө хамруулсан төв болоосой гэж хүсэж байна. Мөн над шиг гэр оронгүй хүмүүсийг ажлын байраар хангаж өгдөг төв байгаасай гэж хүсэж байна.		
20	Боломжийн байна.		
21	Ерөнхийдөө энэ хэвээр байвал маш сайхан байх болов уу.		
22	Гарах үеийн чирэгдлийг багасгаасай.		
23	Энэ чигээрээ их сайхан байгаасай.		
24	Энэ чигээрээ байхад хангалттай.		
25	Тус төвийн үйл ажиллагаа одоо байгаагаараа таалагдаж байна.		
26	Одоо байгаа нь хангалттай.		
	26 санал, хүсэлт	Шүүмж-6	Талархал-20

ХООЛНЫ АМТ ЧАНАР - САНАЛ ХҮСЭЛТИЙН ДЭВТЭР

	Огноо	Санал, хүсэлт	Талархал
1	2024.07.12		Хуушуур амттай байна баярлалаа
2	2024.07.15		Тогооч нартаа баярлалаа
3	2024.07.25		Өнөөдрийн хоол цай маш сайн байлаа
4	2024.07.29		Амт чанартай хоолоор үйлчилдэгт чинь баярлаж явдаг шүү тогооч нартаа
5	2024.08.22	Давс нь бага байна	Өнөөдрийн хоолны амт чанар сайн байна.
6	2024.08.23		Тогооч нартаа баярлалаа. Үргэлж амттай хоол цайгаар үйлчилж байдагт
7	2024.08.24		Өнөөдрийн хоол цай маш амттай байлаа. Тогооч нартаа баярлалаа
8	2024.08.25		Хоолны амт чанар маш сайн тогооч нартаа баярлалаа. Чанартай хоол цай
9	2024.08.26		Халуун сайхан хоол цай хийж өгдөг тогооч нартаа баярлалаа
10			Өнөөдрийн хоол цай амт маш сайн байсан. Гоёо хоол цай хийж өгдөг тогооч нартаа баярлаж явдаг шүү

11	2024.08.27		Сэтгэл хангалуун байна. Хоол цай маш гоё амттай байдаг. Мөн талх гоё амттай байдаг баярлаж явдаг тогооч нартаа.
12	2024.08.28		Хоолны амт чанар амттай байлаа. Тогооч нартаа баярлалаа
13	2024.09.01-2024.09.04		Хоолны амт чанар сайн, амттай байлаа. / 4 /
14	2024.10.07		Хоолны амт чанар оке. Тогооч нартаа баярлалаа.
15	2024.10.24		Сэтгэл санаа хангалуун хоолны амт чанар маш сайн байна. Та бүгдийн ажил төрөлд өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе.
16	2024.10.30	Хоолны амт чанар сайн боловч тогооч Мөнхтогоо харьцаа муу, хүнийг архичин мэтээр харьцдаг. Харьцаагаа засна уу.	Өнөөдрийн хоол цай маш сайн байлаа
17	2024.11.08	Хоолны амт бол дажгүй, гэхдээ анхаарах зүйл нь хоолны амтлагчийг жоохон багасгах, шингэлт удаан учир пүнтүүзтэй хоол бага өгвөл зүгээр.	Хоолны чанар сайн байна. Халуун хоолоор үйлчилсэнд баярлалаа.
18	2024.11.08	Өглөөний мэнд. Хоолны чанар сайн боловч пүнтүүз гоймон бага өгч байвал сайн байна.	Халуун цай хоолоор сэтгэл гарган үйлчилж байгаа гал тогооны хамт олонд талархал илэрхийлье. Хоолны тал дээр амт чанар илчлэг сайн санагдсан.
19	2024.11.08	Пүнтүүз нь хүний биед удаан шингэдэг.Тийм болохоор пүнтүүзийг 7 хоногтоо 1 өгч байвал зүгээр санагдсан. /3 санал/	Тогооч нартаа баярлалаа. Үргэлж амттай хоол цайгаар үйлчилж байдагт баярлалаа. /4 санал/
		Санал - 5	Талархал - 19

ДҮГНЭЛТ

1. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, байрны багш, жижүүр, тогоочийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг 98,3% хувиар маш сайн болон хангалттай гэж үнэлжээ. Энэ нь мэргэжлийн үйл ажиллагаа чанар хүртээмжтэйг харуулжээ.
2. Албан хаагчдын харилцаа хандлага болон төвийн ая тухтай байдал үйлчилгээг 100% маш сайн болон хангалттай гэжээ. Энэ нь тус төвийн үйлчилгээ, ая тухтай байдал болон албан хаагчидын эерэг харилцаа хандлагыг харуулж байна.
3. Төвийн үйл ажиллагаа үйлчилгээний чанар, хүртээмжид, судалгаанд оролцсон нийт иргэдийн 99% маш сайн болон хангалттай гэсэн санал өгсөн. Энэ нь үйлчилгээнд сэтгэл

хангалуун төдийгүй төвийн үйл ажиллагааг энэ хэвээрээ сайн байхыг хүсэн талархал илэрхийлсэн байна.

4. Байгууллагын үйл ажиллагааны өнгөрсөн, одоо, ирээдүйд чиглэсэн нээлттэй асуултад талархал-20, санал хүсэлт-26 , шүүмж-6 ирсэн. Цаашид санал хүсэлт, шүүмжийн дагуу тодорхой чиглэл гарган ажил үйлчилгээгээ сайжруулахад анхааран ажиллах болно.

ХЯНАСАН
АХЛАХ АРГА ЗҮЙЧ

М.МӨНХСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
СЭТГЭЛ ЗҮЙЧ

Б.БУЯНСҮРЭН